

Тушаал



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: 263727
И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2024.12.23 № 2/6745
танай _____-ны № _____-т

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Майкрософт компаний "Оффис 365 систем"-ийг боловсролын салбарт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, аймаг, нийслэлийн Боловсролын газарт админ эрхийг цахим шуудангаар, багшид дээрх системийн АЗ эрх, бусад ажилтан, суралцагч нарт А1 эрхийг үүсгэж боловсролын салбарын мэдээллийн <https://esis.edu.mn/> системээр хүргүүлнэ.

Админ болон хэрэглэгчийн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн үе шаттай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, аймаг, нийслэлийн Боловсролын газрын холбогдох албан хаагчдад сургалт хийхээр төлөвлөсөн тул сургалтыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж, сургалтад хамрагдсан албан хаагчдын бүртгэл, жагсаалтыг цахим шуудангаар [/info@edu.mn/](mailto:info@edu.mn)-д хүргүүлэн, хамтран ажиллах нь зүйтэй.

Сургалтын хуваарь, системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор авна уу.



<https://help.esis.edu.mn/content/23338>

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН



14219 8263

